

# ХУРАЛДААНЫ ТОЙМ

Хуралдаан 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдөр 15 цаг 00 минутад эхэлж, 16 цаг 30 минут хүртэл Засаг даргын зөвлөлийн өрөөнд хуралдав. Хуралдааныг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Ж.Ганбаатар удирдан гишүүдийн 90 хувийн ирцтэйгээр хуралдааныг эхлүүлэв.

Хуралдаанд ороцсон гишүүд: Ж.Гантулга, Л.Бат-Октябрь, Г.Лхагвахатан, Б.Сүнгээ, С.Бат-Эрдэнэ, Ч.Эрдэнэбаатар, Ж.Болд, Б.Баярсайхан, Ч.Болормаа.

| № | ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ   | ГАРСАН ШИЙДВЭР  |
|---|---|---|
| 1 | Хэрлэн сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч Д.Буянбаттай холбоотой Хэрлэн сумын ёс зүйн хорооны дүгнэлт хэлэлцэх | Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн ёс зүйн хорооны дүгнэлтийг хэлэлцээд Хэрлэн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Д.Буянбаттай холбоотой ёс зүйн зөрчлийг шийдвэрлэсэн Хэрлэн сумын ёс зүйн хорооны дүгнэлтийг үнэдслэлтэй гэж үзлээ. Хуралдаанаас гарсан холбогдох шийдвэрийг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Болд, Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Сүнгээ нарт албан бичгээр хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн нарийн бичгийн дарга Ч.Болормаад даалгав. Цаашид төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн харилцаанд анхаарал хандуулан албан хаагчдад сургалт зохион байгуулах чиглэлээр анхааран ажиллах тухай зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв. |
| 2 | 2019 оны Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн төлөвлөгөө хэлэлцэх   | Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны төлөвлөгөөг гаргах ажлын хэсгийг томилов. Ажлын хэсэгт гишүүн Ж.Гантулга, Ч.Болормаа нар томилогдон төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн ажил дүгнэх үзүүлэлтийн дагуу төрийн албаны тухай хууль түүнийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдан гарах дүрэм журмыг хэрэгжүүлэх ажил үүргийн хуваарийг гарган 2 сард багтаан салбар зөвлөлийн даргад танилцуулахыг даалгав.  |
| 3 | ТАЗСЗ-ийн гишүүдэд ТАТХ-ийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдан гарах дүрэм журмуудын жагсаалтыг танилцуулах                  | Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдэд ТАТХ-ийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдан гарах дүрэм журмуудын жагсаалтыг танилцуулав.  |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ